МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.mn, http://www.moh.mn

2015.10.15 № 1а/4143
танай ____________-ны № ____________-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР, ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВИЙН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Мөнгөн тэтгэмж авах
хүмүүсийн нэр хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дах заалтын дагуу 2015 онд өндөр настны тэтгэвэр тогтоолгож мөнгөн тэтгэмж авах хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар хүргүүлж байна.

Эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоол, 2015 оны 338 дугаар тогтоолыг үндэслэн холбогдох баримт, бичгийг бүрдүүлэн батлагдсан төсөвтөө багтаан зохих журмын дагуу тэтгэмжийн мөнгийг олгоно уу.

2015 оны төсөвт тэтгэмжийн мөнгө дутуу батлагдсан бөгөөд үлдэгдэл мөнгө нь 2016 оны төсөвт тусгагдсан тул зөрүүг 2016 онд багтаан олгох болохыг анхаарна уу.

Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаанаар төрийн албан хаагч тэтгэвэр тогтоолгох хугацаагаа хойшлуулж 2016 онд мөнгөн тэтгэмжээ авах бол тухайн хүнд батлагдсан мөнгийг өөр хүнд шилжүүлэн олгож болох бөгөөд Эрүүл мэндийн газар нь бичгээр хүсэлт гарган жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлнэ.

Хавсралт ...... хуудастай

САЙД Г.ШИЙЛЭГДАМБА

087212